**МОНГОЛ УЛС**
**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2022 оны 06 сарын 15 өдөр Дугаар А/255 Мандалговь

Боловсрол, шинжлэх ухааны газрын
бүтэц, орон тоог шинэчлэн
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.12, 65 дугаар зүйлийн 65.1.8, Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоол, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/125 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Боловсрол, шинжлэх ухааны газрын бүтэц, орон тоог хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан орон тоонд багтаан ажилтан, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт, ажил үүргийн хуваарийг шинэчлэн баталж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга (Ц.Уранбямба)-д даалгасугай.

3. Байгууллагын албан хаагчдын цалинг Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолыг үндэслэн цалингийн санд багтаан олгохыг Боловсрол шинжлэх ухааны газрын дарга (Ц.Уранбямба)-д зөвшөөрсүгэй.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны 08 дугаар сарын 27-ны А/298 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралтаар баталсан "Боловсролын газрын бүтэц, орон тоог хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА Ц.МӨНХБАТ

4822100834